

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**СОЛБИЦЛЫН ДЭД ТОГТОЛЦООГ ТОГТООХ,
УЛСЫН СОЛБИЦЛЫН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭХ
ХӨРВҮҮЛГИЙН УТГЫГ ТОДОРХОЙЛОХ ДҮРЭМ**

**УЛААНБААТАР ХОТ
2026 он**

1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн АД/2025-27 дугаар даалгаврыг баримтлан боловсруулав.
2. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/97 дугаар тушаалын хавсралтаар батлав.
3. “Солбицлын дэд тогтолцоог тогтоох, Улсын солбицлын тогтолцоонд шилжүүлэх хөрвүүлгийн утгыг тодорхойлох дүрэм”-ийг 2026 оны 03 дугаар сарын 23 өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

БОЛОВСРУУЛСАН:

О.ХОСБАЯР
ДОКТОРАНТ

ГЕОДЕЗИЙН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР,

ШҮҮМЖ БИЧСЭН:

Ц.ДАШЗЭВГЭ
ДОКТОРАНТ

ГЕОДЕЗИЙН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР,

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

Г.НАРАНТУЯА

ГЕОДЕЗИЙН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР

Энэхүү дүрмийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын зөвшөөрөлгүйгээр бүрэн болон хэсэгчлэн хувилах, олшруулах, тараахыг хориглоно.

ГАРЧИГ

1. ЕРӨНХИЙ ХЭСЭГ	4
Хэрэглэх хүрээ	4
Нийтлэг үндэслэл	4
2. НОРМАТИВ ЭШЛЭЛ	4
3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ.....	4
3.1. Нэр томьёо.....	4
3.2. Товчилсон үгийн тайлбар	6
4. МОНГОЛ УЛСЫН ГЕОДЕЗИЙН СОЛБИЦЛЫН УЛСЫН ТОГТОЛЦОО	6
5. ТОГТОЛЦОО ХООРОНДЫН ХӨРВҮҮЛЭЛТ	13
ХАВСРАЛТ 1. GEOGRAPHIC CALCULATOR программ хангамж дээр систем гараас тохируулах заавар.....	15
ХАВСРАЛТ 2. Олон улсад ашиглаж байгаа солбицлын дэд тогтолцооны судалдаа 17	
Эхлэл өгөгдөхүүн.....	17
ХАВСРАЛТ 3. Монгол улсын аймаг сум, суурин газар, тосгон, уурхайн дэд тогтолцооны код, нэрийн товчлол	21

1. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

Хэрэглэх хүрээ

Энэхүү дүрмийг салбар үл харгалзан Монгол Улсын нутаг дэвсгэрт геодезийн хэмжилт, зураглалын ажил захиалагч болон гүйцэтгэгч бүх шатны байгууллага, аж ахуйн нэгжүүд дагаж мөрдөнө.

Нийтлэг үндэслэл

Энэхүү дүрэм нь Монгол Улсын аймаг, нийслэл, сум, томоохон суурин, уурхайд болон бусад газарт инженерийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, барих, ашиглах ажлуудад геодезийн хэмжилт, зураглалын ажил гүйцэтгэхэд солбицлын дэд тогтолцоог тогтооход ашиглагдана.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэ дүрэмд дор дурдсан норматив баримт бичгийг эш татав. Үүнд:

- 2.1. Геодези, зураг зүйн тухай хууль
- 2.2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоол
- 2.3. Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил. БД 11-104-19
- 2.4. Геодези, зураг зүй. Ерөнхий нэр томъёо, тодорхойлолт MNS:3951-20
- 2.5. Навигацийн хиймэл дагуул (GNSS)-ын технологиор Монгол Улсын геодезийн сүлжээ байгуулах дүрэм БНБД11-13-22
- 2.6. Монгол Улсын өндрийн I ба II ангийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм БНБД11-09-16
- 2.7. Монгол Улсын өндрийн III ба IV ангийн сүлжээ байгуулах дүрэм БД11-121-19
- 2.8. Монгол орны гравиметрийн тулгуур сүлжээ байгуулах дүрэм БНБД11-10-17
- 2.9. Байр зүйн болон дэвсгэр зураглалын ажил БНБД11-06-25

Геодезийн дүрэм батлагдсанаас хойш эшлэл авсан баримт бичигт нэмэлт, өөрчлөлт орсон, шинэчилсэн бол шинэчилсэн баримт бичгийг мөрдөнө.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

3.1. Нэр томъёо

Нэр томъёо, товчлол	Тодорхойлолт
Улсын Геодезийн Тулгуур Сүлжээ (УГТС)	Үндэсний геодезийн тогтолцоо, ITRF тогтолцоонд солбицол нь тодорхойлогдсон AA-I, AA-II зэргийн БАСС-ууд
Гаусс-Крюгер проекц	Гаусс-Крюгерийн тусгаг, хөндлөн меркаторын нэг хувилбар, бүс дотроо аль болох бага гажуудал үүсгэдэг, томоохон газар нутагт тохиромжтой
Олон Улсын Газрын тооллын референц тогтолцоо (ITRF-International Terrestrial Reference Frame)	Байрлал тодорхойлох, хиймэл дагуулын навигаци хийх, үндэсний болон бүс нутгийн солбицлын тогтолцоог тодорхойлоход зориулсан дэлхийн газрын тооллын геотөвт, 3 хэмжээст стандарт тогтолцоо Тайлбар: Энэхүү тогтолцоог дэлхийн навигацийн хиймэл дагуулын систем (GNSS), лазерын хиймэл дагуулын хэмжилтийн систем (SLR), хэт урт суурь шугам хэмжих систем (VLBI), доплерын хиймэл дагуулын хэмжилтийн систем (DORIS) гэсэн огторгуйн геодезийн хэмжилтийн

	үндсэн 4 техникийн өгөгдлийг нэгтгэн боловсруулж тодорхойлдог
Олон Улсын Дэлхийн Эргэлт, Референц тогтолцооны үйлчилгээний байгууллага (IERS-International Earth Rotation and Reference Systems Service)	Квазар, хиймэл дагуул, дэлхийн эргэн тойронд байгуулсан IGS станцуудын өгөгдөл, мэдээг боловсруулан дэлхийн цаг, дэлхийн эргэлтийн параметрууд, солбицлын референц тогтолцооны утгуудаар үйлчилгээ үзүүлдэг олон улсын байгууллага
Байрлалын сүлжээ	GNSS-ийн хэмжилтээр дэлхийн гео-төвт 3 хэмжээст тэгш өнцгийн ITRF болон геодезийн солбицлын тогтолцоонд байрлалыг, геометрийн нивелирдлэгээр ортометрийн өндрийг, гравиметрийн хэмжилтээр хүндийн хүчний утгыг тодорхойлсон цэгүүдийн олонлог
Картезийн солбицлын тогтолцоо, ECEF (Earth Centered Earth Fixed)	Дэлхийн массын төв, дэлхийн гео-төвт 3 хэмжээст тэгш өнцгийн солбицлын систем, тухайн цэгийн XYZ солбицлыг гарган авна.
Геоид	MNS 3951:20. Далайн нам тайван тэнцвэртэй нөхцөлд байх үеийн гадаргуун шугамыг эх газарт үргэлжлүүлэн татахад үүссэн Дэлхийн хэлбэр
Гравиметрийн сүлжээ	MNS 3951:20. Гравиметрийн хэмжилтээр хүндийн хүчний хурдатгалын утгыг тодорхойлж, тэгшитгэн бодсон геодезийн байнгын цэг тэмдэгтийн олонлог
Дэлхийн навигацийн хиймэл дагуулын систем (GNSS-Global Navigation Satellite System)	Объектын орон зайн байрлал, хөдөлгөөний чиглэл, шилжилтийг тодорхойлох зорилгоор байгуулсан хиймэл дагуулын систем <i>Тайлбар: Америкийн GPS, Оросын GLONASS, Европын GALILEO, Хятадын COMPASS/Bei-Dou, Японы QZSS, Энэтхэгийн IRNSS зэрэг навигацийн хиймэл дагуулын системүүд, тэдгээрийн засварыг дамжуулах зорилгоор нэмэлтээр байгуулсан Америкийн WAAS, Оросын SDCM, Европын EGNOS, Японы MSAT, Энэтхэгийн GAGAN хиймэл дагуулын систем хамаарна</i>
WGS84 (World Geodetic System 1984) эллипсоид	WGS84 эллипсоид нь Дэлхийн геодезийн тогтолцоо 1984 (WGS84) солбицлын системийн эхлэл гадаргуу болгон ашигладаг математикийн, дэлхийтэй ойролцоо бөмбөрцөг хэлбэртэй, дэлхийн массын төвд суурилдаг болно.
Сонгож авсан эхлэл цэг (Origin point)	Сонгож авсан эхлэл цэг, дэд тогтолцооны хувьд тооллын эхлэл болно, мөн тэнхлэгийн голдоч эндээс эхэлнэ
Эхлэл цэгийн өргөрөг (Latitude of origin)	Сонгож авсан эхлэл цэгийн өргөрөг
Хойд зүгийн шилжилт (false northing)	Хойд зүгийн шилжилт буюу тусгагийн тооллын эхлэлийг энэхүү шилжилтээс эхлэн хойш нэмэгдэж, урд зүгт хасагдана
Зүүн зүгийн шилжилт (false easting)	Зүүн зүгийн шилжилт буюу тусгагийн тооллын эхлэлийг тэнхлэгийн голдчоос зүүн зүгт нэмэгдэж, баруун зүгт хасагдана
Солбицлын тогтолцоо Pulkovo 1942 (CS-42)	Зөвлөлт холбоот улсад 1942 онд байгуулагдсан солбицлын тогтолцоо, PZ90 Картезийн солбицлын тогтолцоо гэсэн эхлэл өгөгдөхүүнтэй
Красовский 1940 эллипсоид	Красовский эллипсоид нь 1940 онд дэлхийн гадаргуу, хэлбэр, хэмжээсийг Зөвлөлтийн эрдэмтэн тооцоолон гаргасан. Эллипсоидын төв нь солбицлын системийн эхлэлтэй давхцаж, эллипсоидын эргэлтийн тэнхлэг нь дэлхийн эргэлтийн тэнхлэгтэй параллель бөгөөд анхдагч голдчийн хавтгай нь уртрагийн эхлэлийн байрлалыг тодорхойлдог

Тэнхлэгийн голдоч (central meridian)	Хөндлөн меркаторын тусгагийн тэнхлэгийн голдоч, Хавтгай дээр шулуун шугамаар дүрслэгддэг голдоч, өөрөөр хэлбэл бүсийг таллаж хуваасан голдоч.
-----------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

3.2. Товчилсон үгийн тайлбар

Англи үг		
SPCS	State Plane Coordinate Systems	АНУ-ын дэд тогтолцооны нэр, Улсын Хавтгайн солбицлын тогтолцоо
LC1	Lambert Conformal Conic, one parallel	Ламбертын конусан тусгаг, конусыг дэлгэж бөмбөрцөгт шүргэсэн параллелд итгэлцүүр өгдөг
TM	Transverse Mercator	Хөндлөн меркаторын тусгаг, хөндлөн цилиндрийг дэлгэж хавтгай болгодог, итгэлцүүр нь тэнхлэгийн голдоч дээр үнэн байдаг.
UTM	Universal Transverse Mercator	Дэлхийн хөндлөн меркаторын тусгаг, хөндлөн цилиндрийг дэлгэж хавтгай болгодог, 6 градусаар дэлхийг хувааж, тэнхлэгийн голдоч дээрх итгэлцүүр 0.9996, голдчийн 2 талд 180км орчимд параллел шугамууд дээр итгэлцүүр 1
OMC	Hotine Oblique Mercator, center	Martin Hotine-ий зохиосон ташуу меркаторын тусгаг, ташуу цилиндрийг дэлгэдэг, тэнхлэгийн голдоч дээр гажуудал бага байна.
PPM	parts per million	Нэг саяд оногдох хэсэг
ECEF	Earth Centered Earth Fixed	Картезийн солбицлын тогтолцоо, Дэлхийн массын төв, дэлхийн гео-төвт 3 хэмжээст тэгш өнцгийн солбицлын тогтолцоо, тухайн цэгийн XYZ солбицлыг гарган авна.
GSF	Grid Scale factor	Цэгийн тусгагт бодогдсон зайн масштабын итгэлцүүр
ESF	Elevation Scale factor	Цэгийн өндрийн масштабын итгэлцүүр
CSF	Combined Scale factor	Хосолсон масштабын итгэлцүүр
LD	Linear Distortion	Шугаман гажуудал, гажилт
PZ90	Parameter Zemli 1990	Хиймэл дагуулын Глонасс системийн тусламжтайгаар гарган авсан геодезийн эхлэл өгөгдөл (датум)
Орос үг		
МСК	Местные системы координат	ОХУ-ын дэд тогтолцооны нэр, хавтгайн солбицлын тогтолцоо
Монгол үг		
АНУ		Америкийн нэгдсэн улс
ОХУ		Оросын холбооны улс

4. МОНГОЛ УЛСЫН ГЕОДЕЗИЙН СОЛБИЦЛЫН УЛСЫН ТОГТОЛЦОО

4.1. Улсын солбицлын тогтолцоо

4.1.1. Улсын геодезийн сүлжээ байгуулах

Улсын геодезийн сүлжээ гэж Геодези, зураг зүйн тухай хуулийн 1.3.6-д заасан геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тогтолцоог хэлнэ.

Монгол Улсын геодезийн сүлжээ нь байрлал, өндөр, гравиметрийн гурван төрөлтэй байна.

Монгол Улсын байрлалын сүлжээ нь АА, А, В, С гэсэн 4 ангитай, АА ангийн сүлжээ нь АА-I, АА-II, АА-III, АА-IV гэсэн 4 зэрэгтэй байна.

Улсын Геодезийн Сүлжээг Навигацийн хиймэл дагуул (GNSS)-ын технологиор Монгол Улсын геодезийн сүлжээ байгуулах дүрэм БНБД11-32-22-ийг баримтлан байгуулна.

Өндрийн сүлжээг тухайн дэд сүлжээ байгуулах газрын байрлал, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзэж Монгол Улсын өндрийн I ба II ангийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм БНБД11-09-16; Монгол Улсын өндрийн III ба IV ангийн сүлжээ байгуулах дүрэм БД11-121-19-ийг тус тус баримтлан байгуулна.

Гравиметрийн сүлжээг Монгол орны гравиметрийн тулгуур сүлжээ байгуулах дүрэм БНБД11-10-17-г баримтлан байгуулна.

4.1.2. Улсын солбицлын тогтолцоонд тэгшитгэн бодолт хийх

Дээр дурдсан барилгын норм ба дүрэм, барилгын дүрмүүдийг баримтлан тэгшитгэн бодолтыг хийж гүйцэтгэнэ.

4.1.3. Эхлэл өгөгдөхүүн

Дэлхийн массын төв, эргэлтийн тэнхлэгийн чиглэл, эргэлтийн хурд нь дотоод бүтэц, царцдаст давхаргын динамик хөдөлгөөн, огторгуйн гараг эрхсийн нөлөөллөөс хамааран өөрчлөгдөж байдгаас гадна дэлхийн тектоник хавтангууд өөр хоорондоо харьцангуйгаар жигд бус шилжилт хөдөлгөөнд оршдог. Үүнээс шалтгаалан дэлхийн массын төв болон эргэлтийн тэнхлэгт тулгуурлан тодорхойлсон ITRF тогтолцоо нь цаг хугацааны туршид аажим боловч жигд бус шилжих хөдөлгөөнтэй байдаг. Энэхүү шилжилтийн хэмжээ ба чиглэлийн өөрчлөлт хугацааны туршид хол болох үед IERS байгууллагаас ITRF тогтолцооны утгуудыг шинэчилж, ITRF тогтолцооны шинэ хувилбарыг зарладаг. Дэлхийн массын төвөөс эхлэлтэй, гео-төвт Картезийн солбицлыг эхлэл болгон авна.

Өндрийн хувьд Балтийн тэнгисийн өндрийн системд тэгшитгэн бодогдсон I ба II ангийн өндрийн цэгүүдийг эхлэлээ болгон ашиглана.

Гравиметрийн хэмжилт, боловсруулалтыг дээд ангийн цэгүүдтэй харьцангуйгаар хэмжилт хийсэн байна.

4.1.4. Эллипсоидын үзүүлэлтүүд

Монгол улсад WGS84 эллипсоидыг ашигладаг. Уг эллипсоидын үзүүлэлтийг дор харуулав:

Их хагас тэнхлэг:	6 378 137.0 м
Бага хагас тэнхлэг:	6 356 752.314245 м
Шахцал 1/f:	298.257223563
Эксцентритит e^2 :	$6.69437999014 \times 10^{-3}$

4.1.5. Эрин

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн Геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоог шинэчлэн батлах тухай 267 дугаар тогтоолд 1.Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэж байгаа геодезийн хэмжилт, зураглалын ажилд олон улсын геодезийн солбицлын ITRF2020 тогтолцоо, өндрийн сүлжээнд Балтийн тэнгисийн тогтолцоог, газрын зураглалд дэлхийн хөндлөн меркаторын "UTM" тусгагийг тус тус хэрэглэж байхаар тогтсугай.

Энэхүү тогтоолын дагуу Монгол Улсад ITRF2020 тогтолцоо түүний эрин болох 2015.00 (2015 оны эхний өдрийн) утгыг ашиглахаар тогтсон байдаг.

4.1.6. Хэрэглээ

Геодезийн сүлжээг батлан хамгаалах, нутаг дэвсгэрийг зурагжуулах, эрдэм шинжилгээ, судалгааны болон аж ахуйн үйл ажиллагааны дараах ажил, үйлчилгээг явуулахад ашиглана. Үүнд:

а. нутаг дэвсгэрийн хэмжээнд геодезийн солбицлын нэгдсэн системийг тогтоох, цаг үеийн болон ирээдүйн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд;

б. нутаг дэвсгэрийг батлан хамгаалах болон иргэний зориулалтаар зурагжуулахад;

в. газрын болон байгалийн нөөц баялгийг хайх, судлах, олборлох, ашиглах, нөхөн сэргээх геодезийн хэмжилт, зураглалд;

г. дэлхийн гадарга, түүний таталцлын орчны цаг хугацааны өөрчлөлт, геодинамик үзэгдэл, байгаль цаг уур, түүх археологийн судалгааны эрдэм судлалын үйл ажиллагааны геодезийн хэмжилтэд;

д. авто зам, төмөр зам, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, барьж байгуулах, ашиглах үеийн геодезийн хэмжилтэд;

е. газар зохион байгуулалт, хот төлөвлөлт, газрын кадастрын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай геодезийн хэмжилтийн ажилд;

ё. газрын, далайн, агаар-сансрын навигаци болон байгаль орчны хяналт, үнэлгээг геодезийн тулгуур өгөгдлөөр хангахад;

ж. байрлал ба чиглүүлэг тодорхойлох өндөр нарийвчлалтай техник хэрэгслийн хэмжил зүйн баталгаажуулалтын геодезийн жишилтийн полигон байгуулахад.

4.2. Солбицлын дэд тогтолцоо байгуулах аргачлал

4.2.1. Эхлэл цэгийн байрлал сонгох

Солбицлын дэд тогтолцооны эхлэл цэгийн байрлалыг тодорхойлоход дараах дарааллын дагуу хийж гүйцэтгэнэ.

4.2.1.1.1. Дэд тогтолцоо байгуулах нутаг дэвсгэрийн хамрах хүрээ, талбайн хил хязгаарыг тогтоох

4.2.1.1.2. Солбицлын дэд тогтолцооны тогтоосон хил хязгаарын дотор дундаж цэгийн солбицлыг бодож тодорхойлно. Энэхүү цэг нь эхлэл цэг болно.

4.2.1.1.3. Дээрх эхлэл цэгийн солбицлыг сонгохдоо түүнд хамгийн ойр орших геодезийн солбицол болох өргөрөг, уртрагийн бүхэл утга минутын утга руу шилжүүлэн тус утгыг хэрэглэнэ.

4.2.2. Түвшний гадаргуу/хавтгай сонгох

4.2.2.1. Дэд тогтолцоог байгуулах нутаг дэвсгэрт байгаа хамгийн өндөр болон нам цэгүүдийг тодорхойлоод, дундаж түвшинг бодож олно. Дундаж түвшинг эллипсоидын өндрөөр тооцно. Ортометрийн өндөр биш гэдгийг санах хэрэгтэй.

4.2.2.2. Инженерийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, инженерийн дэд бүтэц хэт өндөрлөг газарт харьцангуй бага хийгддэг тул тухайн нутаг дэвсгэрт байгаа уулархаг газрын өндрийг тооцоонд оруулахгүй байвал зохино. Өөрөөр хэлбэл тухайн, аймаг сум нь өндөр уулсын дунд, аль нэг талдаа 25 хувиас дээш налуутай, 50 метрээс өндөр уултай бол тухайн уулын өндрийг түвшний гадаргууг сонгох тооцоололд оруулахгүй.

4.2.2.3. Дундаж түвшин нь сонгож авсан талбайн гадаргуугийн нийтлэг дундаж түвшинтэй ойролцоо байгаа эсэхийг шалгана. Хэрэв энэ зөрүү 5 метрээс өндөр байвал гадаргуугийн нийтлэг дундаж түвшинг түвшний гадаргуу болгон авна.

4.2.3. Геодезийн дэд сүлжээг байгуулах зарчим, арга

Солбицлын дэд тогтолцоог байгуулахдаа доорх зарчмыг баримтална:

4.2.3.1. Солбицлын дэд тогтолцоог Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах;

4.2.3.2. Солбицлын дэд тогтолцоог захиалагчийн зөвшөөрөлгүй дур мэдэн байгуулахгүй байх;

4.2.3.3. Солбицлын дэд тогтолцоог байгуулсан тохиолдолд заавал геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж байж хэрэглээнд нэвтрүүлэх;

4.2.3.4. Солбицлын дэд тогтолцоо нь Монгол Улсын солбицлын тогтолцоонд тулгуурласан байх;

4.2.3.5. Улсын солбицлын тогтолцоо, солбицлын дэд тогтолцоо чөлөөтэй хөрвөдөг байх;

4.2.3.6. Солбицлын дэд тогтолцооны параметр утгуудыг нийтэд ил тод, нээлтэй байлгах;

4.2.3.7. Солбицлын дэд тогтолцоонд хэмжилт, зураглал үйлдэхдээ солбицлын дэд тогтолцооны дугаар, бүсчлэлийг ашиглах;

4.2.3.8. Солбицлын дэд тогтолцооны үйлчлэх талбайг 2500 квадрат километрээс томруулахгүй байх;

4.2.3.9. Дэд тогтолцоонд хөндлөн меркаторын тусгаг ашиглах;

4.2.3.10. Аймаг, нийслэл, сумын төв, хот тосгон, суурин газар бүр дэд тогтолцоотой байх;

4.2.3.11. Хот байгуулалт, уул уурхайн ашиглалт, ашигт малтмалын нөөц тооцоолол, инженерийн барилга байгууламжийн төсөл, тооцоонд шаардлагатай геодезийн хэмжилт, том масштабын дэвсгэр зураглалыг дэд тогтолцоонд гүйцэтгэдэг байх.

Дэд тогтолцоог дараах аргаар байгуулна:

4.2.3.12. Солбицлын дэд тогтолцоог байгуулахад эхлэл цэгийг сонгоно. Эхлэл цэгийг сонгоход энэ дүрмийн 4.2.2.1-ийг баримтална.

- 4.2.3.13. Солбицлын дэд тогтолцоог байгуулахад 4.2.2.2-д заасан түвшний гадаргууг сонгоно.
- 4.2.3.14. Тэнхлэгийн голдчийн утгыг эхлэл цэгтэй харьцангуйгаар минутын бүхэл оронд шилжүүлэн авна. Энэ дүрэмд заасан дугаар, бүсчлэлийг ашиглана.
- 4.2.3.15. Солбицлын дэд тогтолцооны сонгож авсан эхлэл цэгийн масштабын итгэлцүүрийг тооцоолон бодож түүнийг тэнхлэгийн голдоч дээрх масштабын итгэлцүүр болгон ашиглана.
- 4.2.3.16. Эхлэл цэгийн өргөргийг ашиглана
- 4.2.3.17. Хойд зүгийн шилжилт, зүүн зүгийн шилжилтүүдийг Хавсралт 3-ын дагуу оруулна.

4.2.4. Цэг дээрх голдчуудын ойртолт тодорхойлох

Хөндлөн меркаторын тусгагийн хувьд голдчуудын ойртолт нь өнцгийн гажуудалтай тэнцүү байдаг. Голдчуудын ойртолт нь газрын зургийн хойд чиглэл болон геодезийн жинхэнэ хойд зүгийн зөрүү юм. Голдчуудын ойртолт нь тэнхлэгийн голдоч дээр 0, тэнхлэгийн голдчийн зүүн талд эерэг, баруун талд сөрөг утгатай байна. Тэнхлэгийн голдчоос холдох тусам нэмэгдэж, түүний өөрчлөлт нь хойшлох тусам мөн нэмэгддэг.

Хүснэгт 3. Өгөгдсөн өргөрөг дэх голдчуудын ойртолт

Өргөрөг	Тэнхлэгийн голдчоос 1.6км зай дахь голдчуудын ойртолт	Өргөрөг	Тэнхлэгийн голдчоос 1.6км зай дахь голдчуудын ойртолт
0°	0° 00' 00"	50°	±0° 01' 02"
10°	±0° 00' 09"	60°	±0° 01' 30"
20°	±0° 00' 19"	70°	±0° 02' 23"
30°	±0° 00' 30"	80°	±0° 04' 54"
40°	±0° 00' 44"	89°	±0° 49' 32"

Голдчуудын ойртолт /өнцөг/ нь сонгон авсан дэд тогтолцооны талбайн төв цэгээс 25км зайн дотор гажилтын хамгийн бага утга авна. Голдчуудын ойртолт /өнцөг/-ын утгыг ашиглан голдчийн жинхэнэ азимут /хойд чиглэл/-ыг олно.

Голдчуудын ойртолтыг дараах томъёогоор бодож олно.

$$\gamma = -\Delta\lambda \sin \varphi \quad /1/$$

Энд: $\Delta\lambda = \lambda_0 - \lambda$

λ - сонгон авсан дэд тогтолцооны талбайн төв цэгээс тодорхой зайд орших цэгийн уртраг

λ_0 - тэнхлэгийн голдчийн уртраг

φ – цэгийн өргөрөг

4.2.5. Масштабын итгэлцүүр / өндрийн болон тусгагийн итгэлцүүр тооцсон нийлмэл/ тодорхойлох

Дурын цэгийн масштабын итгэлцүүрийг дараах томъёогоор бодож олно.

$$k = k_0 + \frac{(E_0 - E)^2}{2(k_0 * R_G)^2} \quad /2/$$

Энд: E – сонгож авсан эхлэл цэгийн UTM тусгаг дахь /East/ буюу X /абсцисс/
тэнхлэгийн солбицол

E_0 - тэнхлэгийн голдоч дээрх Зүүн зүгийн шилжилт

R_G - эллипсоидын дундаж радиусыг /3/ томъёогоор олно.

k_0 - тусгагийн тэнхлэгийн голдоч дээрх итгэлцүүр

$$R_G = \frac{a\sqrt{1-e^2}}{1-e^2\sin^2\varphi} \quad /3/$$

Энд: a - эллипсоидын их хагас тэнхлэг

e^2 - эллипсоидын эхний эксцентритит

Шулууны хувьд масштабын итгэлцүүрийг дараах томъёогоор бодно олно.

$$k_{12} = \frac{k_1+4k_m+k_2}{6} \quad /4/$$

Энд: k_1 – эхний цэгийн масштабын итгэлцүүр

k_m – дундаж итгэлцүүр

k_2 – хоёрдугаар цэгийн масштабын итгэлцүүр

Энэхүү томъёогоор сонгож авсан талбайн төв цэг дайруулан 4-н шулуунд итгэлцүүрийг бодож тэдгээрийн дунджийг авна.

Сонгож авсан цэгийн өндрийн итгэлцүүрийг дараах томъёогоор бодож олно.

$$k_{\text{өндөр}} = \frac{R}{R+h} \quad /5/$$

Энд: R – эллипсоидын радиус

h – эллипсоидын өндөр

Нийлмэл итгэлцүүрийг дараах томъёогоор бодож олно.

$$k_{\text{нийлмэл}} = k_{\text{өндөр}} * k \quad /6/$$

Эндээс тэнхлэгийн голдоч дээрх итгэлцүүрийг

$$k_{\text{төв}} = \frac{1}{k_{\text{нийлмэл}}} \quad /7/$$

Итгэлцүүрийг таслалаас хойш 8-н оронтой тоон өгөгдлөөр авна.

4.2.6. Солбицлын дэд тогтолцооны үйлчлэх талбай

4.2.6.1. Солбицлын дэд тогтолцоог төлөвлөхдөө үйлчлэх талбайг 2500 квадрат километрээс ихгүй байна.

4.2.6.2. Сонгон авсан солбицлын дэд тогтолцоонд хамаарах талбайн талын урт нь төв цэгээс бүх чиглэлд 25км-ээс ихгүй зайг сонгоно

4.2.6.3. Урт үргэлжилсэн инженерийн шугам сүлжээ, инженерийн дэд бүтцэд зориулж нэг удаа үйлчлэх солбицлын дэд тогтолцоог уртдаа 35км хүртэл болгож болно.

4.2.7. Хил залгах дэд тогтолцоонд шилжүүлэх аргачлал

Хил залгах дэд тогтолцоо хооронд хөрвүүлэлт хийхдээ дэд тогтолцооны параметрүүдэд тулгуурлана. Жишээ болгон Улаанбаатар хот, Налайх дүүрэгт хийсвэрээр

үүсгэсэн дэд тогтолцоо хоорондын хөрвүүлэлтийг газар зүйн тооцооллын (geographic calculator) программ хангамж дээр үзүүллээ.

Улаанбаатар хотод хийсвэрээр үүсгэсэн дэд тогтолцооны параметр утгууд

Тэнхлэгийн голдоч: 106 градус 55 минут; 106°55'
 Эхлэл цэгийн өргөрөг: 47 градус 55 минут; 47°55'
 Масштабын итгэлцүүр: 1.00032868
 Зүүн зүгийн шилжилт: 100000
 Хойд зүгийн шилжилт: 500000

Налайх дүүрэгт хийсвэрээр үүсгэсэн дэд тогтолцооны параметр утгууд

Тэнхлэгийн голдоч: 107 градус 15 минут; 107°15'
 Эхлэл цэгийн өргөрөг: 47 градус 46 минут; 47°46'
 Масштабын итгэлцүүр: 1.00028486
 Зүүн зүгийн шилжилт: 200000
 Хойд зүгийн шилжилт: 500000

Хил залгаа дэд тогтолцоонд шилжүүлэхэд гарсан үр дүнг Хүснэгт 4-д үзүүллээ.

Хүснэгт 4. Хил залгаа дэд тогтолцоонд шилжүүлэхэд гарсан үр дүн

	Улаанбаатар хотод хийсвэрээр үүсгэсэн дэд тогтолцоо			Налайх дүүрэгт хийсвэрээр үүсгэсэн дэд тогтолцоо		
	East	North	Зай	East	North	Зай
Улаанбаатараас Налайх тогтолцоо руу хөрвүүлсэн байдал						
1	125,000.00	500,000.00	5,000.00	200,076.44	516,628.70	4,999.74
2	125,000.00	505,000.00	5,000.00	200,098.03	521,628.40	4,999.73
3	130,000.00	505,000.00	5,000.00	205,097.72	521,606.80	4,999.73
4	130,000.00	500,000.00	5,000.00	205,076.13	516,607.12	4,999.74
4-5 зай			30,000.00			29,998.64
5	100,000.00	500,000.00	5,000.00	175,077.77	516,736.64	4,999.82
6	100,000.00	505,000.00	5,000.00	175,099.36	521,736.41	4,999.81
7	105,000.00	505,000.00	5,000.00	180,099.13	521,714.81	4,999.80
8	105,000.00	500,000.00	5,000.00	180,077.53	516,715.05	4,999.81
5-8 зай			30,000.00			29,998.92
9	100,000.00	470,000.00	5,000.00	174,948.51	486,738.00	4,999.82
10	100,000.00	475,000.00	5,000.00	174,970.02	491,737.78	4,999.81
11	105,000.00	475,000.00	5,000.00	179,969.78	491,716.27	4,999.80
12	105,000.00	470,000.00	5,000.00	179,948.28	486,716.51	4,999.81
Налайхаас Улаанбаатар тогтолцоо руу хөрвүүлсэн байдал						
13	94994.288	483241.035	5,000.17	170,000.00	500,000.00	5,000.00
14	94972.742	488241.154	5,000.17	170,000.00	505,000.00	5,000.00
15	99972.869	488262.708	5,000.18	175,000.00	505,000.00	5,000.00
16	99994.415	483262.573	5,000.17	175,000.00	500,000.00	5,000.00
13-17 зай			30,001.27			30,000.00
17	124995.278	483370.266	5,000.26	200,000.00	500,000.00	5,000.00
18	124973.732	488370.477	5,000.26	200,000.00	505,000.00	5,000.00
19	129973.95	488392.032	5,000.27	205,000.00	505,000.00	5,000.00

20	129995.497	483391.805	5,000.27	205,000.00	500,000.00	5,000.00
17-21 зай			30,001.55			30,000.00
21	125124.235	453368.998	5,000.26	200,000.00	470,000.00	5,000.00
22	125102.781	458369.21	5,000.27	200,000.00	475,000.00	5,000.00
23	130103	458390.672	5,000.27	205,000.00	475,000.00	5,000.00
24	130124.454	453390.445	5,000.26	205,000.00	470,000.00	5,000.00

5. ТОГТОЛЦОО ХООРОНДЫН ХӨРВҮҮЛЭЛТ

- 5.1. Улсын солбицлын тогтолцоог дэд тогтолцоо руу хөрвүүлэх аргачлал, параметр тодорхойлох
- 5.2. Солбицлын дэд тогтолцоог Улсын солбицлын тогтолцоонд хөрвүүлэх аргачлал, параметр тодорхойлох

Дээрх хөрвүүлэлтийг хийхдээ дэд тогтолцооны параметруудад тулгуурлан, нөгөө талд UTM тусгагийн параметруудийг ашиглана. Дэд тогтолцоо нь ижил датум, эллипсоид ашиглаж байгаа тул дурын хөрвүүлэлтийн программ хангамжаар ямар нэгэн алдаагүйгээр хөрвөнө.

Жишээ болгон Улаанбаатар хотод хийсвэрээр үүсгэсэн дэд тогтолцоог Улсын солбицлын тогтолцоо руу болон буцаагаад Улсын солбицлын тогтолцооноос дэд тогтолцоо руу хөрвүүлэлтийг газар зүйн тооцооллын (geographic calculator) программ хангамж дээр үзүүллээ.

Улаанбаатар хотод хийсвэрээр үүсгэсэн дэд тогтолцооны параметр утгууд

Тэнхлэгийн голдоч: 106 градус 55 минут; 106°55'

Эхлэл цэгийн өргөрөг: 47 градус 55 минут; 47°55'

Масштабын итгэлцүүр: 1.00032868

Зүүн зүгийн шилжилт: 100000

Хойд зүгийн шилжилт: 500000

- 5.3. Хөрвүүлэлтийн жишээ тайлбар

Хүснэгт 5. Тогтолцоо хооронд хөрвүүлэхэд гарсан үр дүн


	Улаанбаатар хотод хийсвэрээр үүсгэсэн дэд тогтолцоо			Улсын солбицлын тогтолцоо, UTM тусгаг		
	East	North	Зай	East	North	Зай
Улаанбаатар дэд тогтолцооноос Улсын солбицлын тогтолцоо руу хөрвүүлсэн байдал						
1	125,000.00	500,000.00	5,000.00	668,183.62	5,309,436.59	4,998.06
2	125,000.00	505,000.00	5,000.00	668,059.46	5,314,433.10	4,998.10
3	130,000.00	505,000.00	5,000.00	673,056.02	5,314,557.30	4,998.14
4	130,000.00	500,000.00	5,000.00	673,180.18	5,309,560.70	4,998.10
4-5 зай			30,000.00			29,987.29
5	100,000.00	500,000.00	5,000.00	643,202.14	5,308,816.11	4,997.62
6	100,000.00	505,000.00	5,000.00	643,078.01	5,313,812.18	4,997.66
7	105,000.00	505,000.00	5,000.00	648,074.12	5,313,936.36	4,997.70
8	105,000.00	500,000.00	5,000.00	648,198.26	5,308,940.20	4,997.66
5-8 зай			30,000.00			29,985.74

9	100,000.00	470,000.00	5,000.00	643,945.06	5,278,839.57	4,997.63
10	100,000.00	475,000.00	5,000.00	643,821.46	5,283,835.67	4,997.67
11	105,000.00	475,000.00	5,000.00	648,817.60	5,283,959.32	4,997.72
12	105,000.00	470,000.00	5,000.00	648,941.21	5,278,963.13	4,997.67
Улсын солбицлын тогтолцооноос Улаанбаатар дэд тогтолцоо руу хөрвүүлсэн байдал						
13	129805.886	499443.739	5,001.86	673,000.00	5,309,000.00	5,000.00
14	129930.125	504444.055	5,001.82	673,000.00	5,314,000.00	5,000.00
15	134930.396	504319.773	5,001.77	678,000.00	5,314,000.00	5,000.00
16	134806.159	499319.545	5,001.82	678,000.00	5,309,000.00	5,000.00
13-17 зай			30,012.74			30,000.00
17	99802.399	500188.943	5,002.39	643,000.00	5,309,000.00	5,000.00
18	99926.65	505189.787	5,002.34	643,000.00	5,314,000.00	5,000.00
19	104927.449	505065.494	5,002.30	648,000.00	5,314,000.00	5,000.00
20	104803.201	500064.738	5,002.34	648,000.00	5,309,000.00	5,000.00
17-21 зай			30,014.32			30,000.00
21	99058.746	470183.833	5,002.39	643,000.00	5,279,000.00	5,000.00
22	99182.467	475184.69	5,002.34	643,000.00	5,284,000.00	5,000.00
23	104183.279	475060.926	5,002.30	648,000.00	5,284,000.00	5,000.00
24	104059.56	470060.157	5,002.34	648,000.00	5,279,000.00	5,000.00

ХАВСРАЛТ 1. GEOGRAPHIC CALCULATOR программ хангамж дээр систем гараас тохируулах заавар


Программ хангамж дээр оруулах заавар:

1. Гараас шинэ координат систем оруулна.




Зураг 1. Шинээр координатын систем оруулах

2. Шинэ бүлэг үүсгэнэ дараа нь шинэ систем үүсгэнэ.



Зураг 2. Шинэ бүлэг, шинэ системийн нэрийг өгөх

3. Дэд тогтолцооны нэр болон параметруудийг гараас оруулж өгнө




Зураг 3. Параметр утгуудыг гараас оруулж өгөх

ХАВСРАЛТ 2. Олон улсад ашиглаж байгаа солбицлын дэд тогтолцооны судалдаа
Эхлэл өгөгдөхүүн

АНУ-ын хувьд SPCS (State Plane Coordinate Systems – Улсын Хавтгайн Координатын Систем) гэж нэрлээд 1933 оноос эхлэн мөрдөж эхэлсэн байна.

1. SPCS 1927 систем нь 134 зонд хуваагддаг, 1933-1986 он хүртэл 53 жил мөрдөгдсөн
2. SPCS 1983 систем нь 125 зонд хуваагддаг, 1986-2026 он хүртэл 40 жил мөрдөгдөнө
3. SPCS 2022 систем нь 967 зонд хуваагддаг, 2026 оноос мөрдөгдөнө



Зураг 4. АНУ-ын дэд тогтолцооны бүсчлэлийг харуулсан байдал

АНУ-ын хувьд 3-н төрлийн тусгаг ашиглаж байна. Lambert Conformal Conic, one parallel (LC1), Transverse Mercator (TM), Hotine Oblique Mercator, center (OMC) тусгааг ашиглаж байна. Гажуудалыг 50ppm буюу 1км-т 5см дотор өөрөөр хэлбэл харьцангуй алдааг 1:20000-аас сайжруулна гэсэн зорилготой.

ОХУ-ын хувьд МСК (Местные системы координат) гэж нэрлээд 2007 оноос мөрдөж эхлэсэн. Үүнээс өмнө үед орон нутгийн солбицлын системийг тухай бүрт нь байгуулж ирсэн түүхтэй. МСК1-ээс МСК89 хүртэл хуваасан бөгөөд дотроо 250 бүсд хуваагдсан байдаг. Гаусс-Крюгер-гийн тусгаг ашиглаж байна.



Зураг 5. ОХУ-ын дэд тогтолцооны бүсчлэлийг харуулсан байдал

Солбицлын дэд тогтолцооны параметр утга

АНУ-ын хувьд 3-н төрлийн тусгаг ашиглаж байна.

Газрын тооллын референц тогтолцоо болох Terrestrial Reference Frame (TRF2022); NATRF2022 (North American TRF2022); PATRF2022 (Pacific TRF2022); MATRF2022 (Mariana TRF2022); CATRF2022 (Caribbean TRF2022) эдгээрийг эхлэл өгөгдлөө болгон ашиглаж байрлал тодорхойлох, хиймэл дагуулын навигаци хийх, үндэсний болон бүс нутгийн солбицлын тогтолцоог тодорхойлоход зориулсан дэлхийн газрын тооллын гео-төвт, 3 хэмжээст стандарт тогтолцоог ашиглаж байна. Доорх хүснэгтэд дэд тогтолцооны параметр утгуудыг үзүүлсэн. 967 бүсэд хуваагддаг учир бүгдийг оруулах боломжгүй жишээ болгон үзүүллээ.

Хүснэгт 1. АНУ-ын дэд тогтолцооны параметр утгуудын хэсгээс

Бүсийн код	Тусгаг ийн төрөл	Өргөргийн эхлэл	Уртрагийн эхлэл, Тэнхлэгийн голдоц	Эхлэл цэгийн тусгагийн итгэлцүүр	Эргэлт ийн азимут (deg)	Хойд зүгийн шилжилт (m)	Зүүн зүгийн шилжилт (m)
21015	OMC	64°00'N	210°00'E	1.00006	77	914,400	1,181,100
21016	TM	53°15'N	216°00'E	1		0	1,524,000
21017	LC1	65°09'N	213°00'E	1.00001		876,300	1,333,500
21018	LC1	64°21'N	199°30'E	0.99996		914,400	1,485,900
21019	LC1	66°51'N	199°00'E	0.99991		952,500	1,562,100
21020	LC1	67°06'N	213°00'E	0.99998		914,400	1,409,700
21021	LC1	69°54'N	206°00'E	0.99998		1,028,700	1,790,700
22001	OMC	63°24'N	216°18'E	1.000067	-47	152,400	762,000
22002	OMC	66°51'N	204°12'E	1.000019	-83	152,400	838,200
22003	OMC	67°51'N	204°33'E	1.000058	-79	114,300	838,200

551026	TM	44°00'00.00000"N	269°09'20.53253"E	1.0000353		0	121,920
551027	TM	42°13'00.00000"N	272°06'20.00000"E	1.00002606		0	190,500
551028	TM	43°16'00.00000"N	272°27'00.00000"E	1.00002337		0	228,600
551029	TM	43°27'04.00000"N	268°41'00.00000"E	1.000032		0	137,160
551030	LC1	45°09'15.25358"N	270°58'00.00000"E	1.0000627		106,680	201,930
551031	TM	44°50'40.00000"N	270°16'00.00000"E	1.0000599		0	121,920
551032	LC1	44°54'03.25593"N	270°13'48.00000"E	1.00005329		57,150	133,350
551033	TM	44°41'30.00000"N	272°17'20.00000"E	1.0000235		0	243,840
551034	TM	44°43'00.00000"N	271°35'00.00000"E	1.00003625		0	110,490
551035	LC1	44°00'00.26614"N	269°21'30.00000"E	1.00004341		121,920	209,550

<https://ngs.noaa.gov/SPCS/> холбоосоор дэлгэрэнгүй мэдээллийг үзэх боломжтой.

ОХУ-ын хувьд Гаусс-Крюгерийн тусгаг ашиглаж байна.

Тусгаг: Гаусс-Крюгер, Хөндлөн меркатор

Датум: Pulkovo 1942

Эллипсоид: Красовский 1940

Тэнхлэгийн голдоч: тухайн бүс нутгаас хамаарч өөр өөр байна

Өргөрөг: 0

Итгэлцүүр: 1

Зүүн зүгт шилжилт: Байрлалаасаа хамаарч өөр өөр байна

Хойд зүгт шилжилт: Байрлалаасаа хамаарч өөр өөр байна

Доорх хүснэгтэд дэд тогтолцооны параметр утгуудыг үзүүлсэн. 250 бүсэд хуваагддаг учир бүгдийг оруулах боломжгүй жишээ болгон үзүүллээ.

Хүснэгт 2. ОХУ-ын дэд тогтолцооны параметр утгуудын хэсгээс

Бүсийн код	Тусгаг ийн төрөл	Өргөргийн эхлэл	Уртрагийн эхлэл, тэнхлэгийн голдоч	Эхлэл цэгийн тусгагийн итгэлцүүр	Хойд зүгийн шилжилт (m)	Зүүн зүгийн шилжилт (m)
МСК-46 Курской области						
МСК46 зона 1	TM	0	35°29'0"E	1	-5312900.566	1250000
МСК46 зона 2	TM	0	38°29'0"E	1	-5312900.566	2250000
МСК-03 Республика Бурятия ГОСТ 51794-2008						
МСК03 зона 1	TM	0	100°2'E	1	-5211057.63	1250000
МСК03 зона 2	TM	0	103°2'E	1	-5211057.63	2250000
МСК03 зона 3	TM	0	106°2'E	1	-5211057.63	3250000

МСК03 зона 4	TM	0	109°2'E	1	-5211057.63	4250000
МСК03 зона 5	TM	0	112°2'E	1	-5211057.63	5250000
МСК03 зона 6	TM	0	115°2'E	1	-5211057.63	6250000
МСК03 зона 7	TM	0	118°2'E	1	-5211057.63	7250000

<https://terraingis.ru/> холбоосоор дэлгэрэнгүй мэдээллийг үзэх боломжтой.

ХАВСРАЛТ 3. Монгол улсын аймаг сум, суурин газар, тосгон, уурхайн дэд тогтолцооны код, нэрийн товчлол

Тухайлсан дугаар	Аймаг, сум	Дэд тогтолцооны код	Дэд тогтолцооны нэрийн товчлол	Дэд тогтолцооны нэр	Аймаг, сумын нэр	Зүүн зүгийн шилжилт	Хойд зүгийн шилжилт
Архангай							
1	Батцэнгэл сум	65100	ARBAT	BATTSENGEL	Arkhangai	675,000.000	4,850,000.000
2	Булган сум	65120	ARBUL	BULGAN	Arkhangai	475,000.000	4,625,000.000
3	Жаргалант сум	65200	ARJAR	JARGALANT	Arkhangai	450,000.000	5,050,000.000
4	Ихтамир сум	65170	ARIHT	IKHTAMIR	Arkhangai	500,000.000	4,800,000.000
